

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ТУЛПАР ХК

2021 оны 02 дугаар
сарын 17-ны өдөр

№ 08

Өлгий сум

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Тулпар ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай асуудлаар хэлэлцэж, олонхийн саналыг үндэслэн ТОГТООХ нь :

1. Тулпар ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2021 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 15:00 цагт Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 13-р багийн Тулпар ХК-ны байр сургалтын танхимд зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэхээр оруулсугай.
 - 2020 оны компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудиторын дүгнэлт
 - 2020 оны компанийн үйл ажиллагааны тайлан
 - ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүн сонгох
 - Компанийг өөрчлөн байгуулах төсөл /ХК-г ХХК болгон өөрчлөх/
 - 2021 оны зорилт, бусад асуудал
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2021 оны 03 дугаар сарын 09-ны өдрөөр тогтоосугай.
4. Компанийн ээлжит хурлыг хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг хүргэхээр 2021 оны 02 дугаар сарын 22-ны өдрөөр өдөр тутмын 2-оос доошгүй сонин болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх. Энэ мэдээллийг дээрхи хэлбэр шаардлагын дагуу анх мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа дахин мэдээлж хөрөнгийн биржийн цахим хуудсанд тавихыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
5. Ээлжит хурлын дэгийг 01 дүгээр хавсралтаар, хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь энэхүү шийдвэрийн 02 дугаар хавсралтанд заасан бичиг баримтыг

ажлын өдрүүдэд 09:00-17:00 цагийн хороонд Тулпар ХК-ны байранд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга С.Нурланаас танилцах эрхтэй болохыг дурдсугай.

6. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас” -ын агуулгыг 03 дугаар хавсралтаар баталсугай.
7. Хувьцаа эзэмшигчдээс санал авах хуудсыг хүлээн авах сүүлийн өдрийг харьяалагдах брокер, дилерийн компаниар дамжуулан хурал хуралдах өдрөөс ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө байхаар тогтоосугай.
8. Компанийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.6 -д заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах үед хувьцаа эзэмшигчдийг компанийн холбогдох бичиг материалтай танилцуулахыг ТУЗ-ын нарийн бичгийн дарга С.Нурланд даалгасугай.

ТУЗ-ийн дарга



М.Жанатхан

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ТУЛПАР ХК

2021 оны 02 дугаар
сарын 17-ны өдөр

№ 07

Өлгий сум

ТУЛПАР ХК-НЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Тулпар ХК-ны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2021 оны 04 дүгээр сарын 15-ний өдрийн 15:00 цагт Тулпар ХК-ны байранд хуралдах тул хувьцаа эзэмшигчдийг хүрэлцэн ирэхийг урьж байна.

Хаяг : Баян-Өлгий аймаг, Өлгий сумын 13-р баг, Тулпар ХК-ны байр, сургалтын танхимд мөн цахимаар болно.

Хурлаар хэлэлцэх асуудлууд :

1. 2020 оны компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудиторын дүгнэлт
2. 2020 оны компанийн үйл ажиллагааны тайлан
3. ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулан сонгох
4. Компанийг өөрчлөн байгуулах төсөл /ХК-г ХХК болгон өөрчлөх/
5. 2021 оны зорилт, бусад асуудал

Хурлын материал, гарах шийдвэрийн төсөл болон холбогдох баримт бичигтэй цахимаар болон ажлын өдрүүдэд 09:00-17:00 цагийн хороонд Тулпар ХК-ны байранд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга С.Нурланаас танилцах боломжтой.

Хурал зохион байгуулах комиссын дарга: Танхай овогтой Жумахан

Утас 99422199

Нарийн бичгийн дарга : С.Нурлан

Утас: 99422805

И-мэйл : Nurlan_nic@yahoo.com

Захирал



Т.Жумахан